



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/219

Булган

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах
эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 10/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгагдсан Могод сумын Засаг даргын Тамгын газрын барилгыг шинээр барих ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан Улаанбаатар хотын “Эм Би Эф” ХХК-тай 799 787 271 /долоон зуун ерэн есөн сая долоон зуун наян долоон мянга хоёр зуун далан нэг/ төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Ү.Бямбасүрэн/-т олгосугай.

2. Дээрх ажлын гүйцэтгэгчтэй холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулж, гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Д.Буманбаяр/, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Ү.Бямбасүрэн/ нарт тус тус үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль тогтоомж, стандартын дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Эм Би Эф” ХХК-ийн захирал /Г.Цэрэндорж/-д даалгасугай.

4. Гэрээт ажлыг гүйцэтгэх хугацаанд “Эм Би Эф” ХХК-ийн ирүүлсэн саналын дагуу орон нутгийн ажилгүй иргэдээс 15 хүн ажиллуулж буй эсэхэд хяналт тавихыг аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар /Н.Батжаргал/-д үүрэг болгосугай.


5. Энэхүү ажлын санхүүжилтыг 2019 оны Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Д.Батцогт/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ

Аймгийн Засаг даргын 2019 оны 04 сарын
04 өдрийн дүгээр захирамжийн хавсралт



| № | Нөхцөл шаардлага | Мөнгөн дүн |
|---|--|--|
| 1 | Зураг төсвийн үнэ | 0 |
| 2 | Магадлашгүй ажил | 12 325 348 |
| 3 | Техник хяналтын зардал | 12 325 348 |
| 4 | Зураг төсөв зохиогчийн хяналтын зардал | 6 162 674 |
| 5 | Орон нутгаас авах ажиллах хүчний тоо | 15 |
| 6 | Алданги | Хоногт гэрээний үнийн 0.2 хувь, нийт алданги гэрээний үнийн 10 хувь байна. |
| 7 | Ажил гүйцэтгэх хугацаа | 168 хоног |